

2019



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО

Энэхүү баримт бичиг нь Хүүхдийн эрхийн тухай хууль,, Хүүхэд хамгааллын тухай хуулиар үүрэг хүлээсэн талууд болон хүүхэд, гэр бүлтэй шууд ба шууд бусаар тулж ажилладаг байгууллагад хамаарна. Үүнд хүүхэд, хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, хууль цагдаагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн, дотоод, гадаадын, олон улсын төрийн бус, хувийн хэвшлийн бүх байгууллагууд орно.

Хүүхэд хамгааллын бодлого гэж юу вэ?

Хүүхэд хамгааллын бодлого: Хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, оролцогч талуудын харилцааг тодорхойлж, хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлж, нийгмийн бүхий л орчинд хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой мэргэшсэн үйл ажиллагаанд холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хүүхэд хамгааллыг төрийн үйлчилгээний нэг төрөл, хэлбэр болгох нь хүүхдийг үл хайхрах, хүчирхийлэх, мөлжих явдлаас сэргийлэх, хамгаалах тогтолцоог хөгжүүлэх, улсын онц болон онцгой байдлын үед хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хангахад бэлэн байх асуудал бол хүүхэд хамгааллын бодлогын салшгүй хэсэг гэж ойлгоно.

Хүүхэд гэдэг бол нийгмийн бүхий л орчинд ямар нэгэн хүчирхийлэл дарамтанд өртөх эрсдэлтэй хүн амын бүлэг юм. 3 хүн тутмын 1 нь хүүхэд хэмээн бүртгэгдсэн манай улсад 2017 оны байдлаар гэмт хэргийн улмаас нас барсан хүүхдийн тоо 127-д хүрсэнээс зам тээврийн осолд өртөж 55 хүүхэд нас барсан, хүчингийн гэмт хэргийн улмаас 187 хүүхэд хохирсон байгаагаас бага насны, нярай хүүхдүүд мөн 12 эрэгтэй хүүхэд хүчиндүүлсэн хэрэг гарсан бөгөөд нийт 1692 гэмт хэргийн улмаас 1757 хүүхэд хохирсон байна. Нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйлээс шалтгаалан хүүхдийн эрх зөрчигдсөөр байгаа энэ үед хууль ёсны зохих эрхээ эдэлж чадахгүйд хүрсэн хүүхдийн эрсдэлтэй, аюултай, эмзэг нөхцөл байдлыг үнэлэх, төрөөс тэдэнд үзүүлэх үйлчилгээг төлөвлөх, хамгаалах зайлшгүй шаардлагатай байна.

Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх нь хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох үндсэн эрхүүд хангагдах суурь нөхцөлийг баталгаажуулах үндэс юм.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО

2019 оны 02сарын 18

Нэг: Нийтлэг үндэслэл

Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн Эрхийн тухай Конвенц, Монгол улсын хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн дагуу хүүхэдаливаадарамт, хүчирхийлэл, мөлжлөг, үлхайхрах явдлаас хамгаалуулах эрхтэй бөгөөд нас сэтгэхүйн онцог байдлын улмаас хүүхэд бүр хүчирхийлэл, дарамт мөлжлөг, үл хайхрах байдалд өртөх эрсдэлтэй байдаг.

Хүүхдийн эсрэг дарамт, хүчирхийлэл, мөлжлөг, үлхайхрах байдал зэрэг зүйлс бүх хандлагань хүүхдийн жам ёсны эрх болохыг дагас хүйдсээ сангид, халдашгүй дархан байх эрхэмсэг чанарыг үгүйсгэсэн хүүхдийн эрхийн ноцтой зөрчил мөнб өгөөдхэзээ ч зөвтгөж болохгүй, харин урьдчилан сэргийлж болох, ёс зүй, хууль эрх зүйн хүрээнд хүн бүрт хамаатай асуудал юм.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэлийг үйлдэгч нь хүүхдэд ойр дотно, түүний итгэлийг даах хүмүүс байдаг нь элбэг байдаг. Иймд хүүхэд гэр бүлтэй ажилладаг байгууллага хүмүүс хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийг хүчирхийллээс хамгаалахад өөрсдийн гүйцэтгэх үүргийн тухай сайн ойлгох шаардлагатай. Бид үйлчилж байгаа болон хамтран ажиллаж байгаа бүх хүүхдийг дээд зэргээр хамгаалах бүхий л арга хэмжээг авна.

1.1 ХҮҮХЭД ХАМГААЛАГДААГҮЙН ХОР УРШИГ

Хэрэв хүүхдийн хамгаалуулах эрхийг хангаж чадахгүй бол үрдагавар нь хүүхэд би ем ахбод, сэтгэл санааны гэмтэл бэртэлавах, өвчлөх, биеийн болон сэтгэцийн хөгжил, төлөвшил нь хоцрогдох, сургууль завсардах, гэр бүлийн халамжасрамжаас гадуур гудамжинда мьдрах, улмаар амьзогоохын эрхээр хөдөлмөр эрхлэх, мөлжлөгт өртөх, худалдагдах, хууль зөрчих, гэмт хэрэг үйлдэх, архи, тамхи, мансууруулах бодист донтох, амиа хорлох зэрэг нийгмийн сөрөг үзэгдлийг бий болгодог.

1.2 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН АРГА АЖИЛЛАГАА БА АЙМГИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ОРОН НУТГИЙН БОДЛОГО

Энэ нь ажилтан, албан хаагчдад чиглэсэн байгууллагын дотоод бодлого бөгөөд хүүхдэд учрах эрсдэл, хор хөнөөлөөс хамгаалж сэргийлэхийн тулд байгууллага бүр анхаарал тавьж байгааг нотолсон баримт бичиг. Хүүхэдтэй ажиллагаадаг байгууллагын Хүүхэд хамгааллын бодлогод хүүхэд бүрт аюулгүй, эерэг орчин бүрдүүлэхийн тулд байгууллага ажилтнууд, сайн дурын идэвхитнүүд болон бусад холбогдох хүмүүс юуг анхаарах ёстойг заасан байна.

Хүүхэд нийгмийн бүхий л орчинд хуулиараа хамгаалагдах эрхтэй бөгөөд хүчирхийлэл дарамтанд өртөх эрсдэлтэй хүн амын бүлэг бөгөөд хүүхдийн төлөө

болон хүүхэдтэй ажилладаг байгууллага, салбарын үйлчилгээг авах явцад хүчирхийлэл шийтгэлд өртөх явдал байдаг. Иймд хүүхэд гэр бүлтэй ажилладаг байгууллага, хүмүүс хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийн аливаа эрсдэл, хүчирхийллээс хамгаалахад өөрсдийн гүйцэтгэх үүргийн тухай сайн ойлгох шаардлагатай бөгөөд эдгээр байгууллагуудад илүү өндөр шаардлага тавигдана. Эдгээр байгууллагууд нь хүүхэдтэй ажиллахдаа тэднээр үйлчлүүлж байгаа болон хамтарч ажиллаж байгаа хүүхдийг дээд зэргээр хамгаалах бүхий л арга хэмжээг авах ёстой.

Хүүхэд, гэр бүлтэй шууд ба шууд бусаар ажилладаг байгууллагууд тусгайлсан Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх нь олон улсын стандарт бөгөөд энэ нь байгууллагыг аливаа эрсдэлээс хамгаалах арга юм. Хүүхдийг хамгаалахад орон нутгийн бодлого, салбаруудын хамтын ажиллагаа, зохицуулалт, мэдээлэл, судалгаа, статистик, хэрэгтэйгээс гадна нийгмийн эерэг хэм хэмжээ, нийт иргэдийн ойлголт, хандлага, зан үйл бүрдэх, хүүхэд аюулгүй орчинд хамгаалагдан амьдрахад нэн чухал үүрэг гүйцэтгэнэ.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА НЬ: Хүүхэд, гэр бүлийн төлөө болон хүүхэд, гэр бүлтэй шууд тулж ажилладаг байгууллагууд өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллах бөгөөд энэ загварыг хүүхэд, хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, хууль, цагдаагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн байгууллага наад захын шаардлага болгон хэрэгжүүлэх бөгөөд дараах үндсэн зарчмуудыг баримталж ажиллана.

ҮНДСЭН ЗАРЧМУУД

Хүүхдийн эрхийг дээдлэх:

Бид хүүхдийн эрх, язгуур эрх ашиг, тэдний аюулгүй байдлыг нэгдүгээрт тавина.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг огт хүлээн зөвшөөрөхгүй:

Манайхамтолон хүүхдийн эсрэг хүчирхийллийн аливаа хэлбэртэй хэзээ ч эвлэрэхгүй. Хүүхдийн аюулгүй байдал, сайн сайханд эрсдэл учруулах хүнийг хүүхэдтэй ажиллах, хамт олны дунд байхыг хүлээн зөвшөөрөхгүй.

Хүүхдэд хор хөнөөл учруулахгүй байх:

Бид үйл ажиллагаагаа төлөвлөж, хэрэгжүүлэхдээ хүүхдийг ямар нэг дарамт, хүчирхийлэл, мөлжлөг, ялгаварлан гадуурхагдах байдалд оруулахгүйгээр, хүүхдийн эрх ашгийг дээд зэрэгт тавихаар зохион байгуулна.

Эрсдэлийг тооцох, үнэлэх, сэргийлэх:

Бидний явуулж байгаа үйл ажиллагаанд хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах байдалд оруулж болзошгүй аливаа эрсдэл байгаа эсэхийг судалж, эрсдэлийг бууруулах, хор нөлөөг нь багасгахад байнга анхаарч ажиллана.

Байгууллага бүр хүүхдийг зүй бус хандах бүхий л хэлбэрээс:

1. Хэрхэн урьдчилан сэргийлэх
2. Эрсдэлийг хэрхэн бууруулах
3. Зөрчил гарсан тохиолдолд мэдээллэдэг механизмыг бий болгох
4. Хариу үйлчилгээг шуурхай үзүүлэх гэсэн загвараар хүүхэд бүхий л орчинд хамгаалагдсан байна.

ХОЁР: ЗОРИЛГО

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, мөлжлөг, үйл хайхрах байдал нь хүүхдийн эрхийн ноцтой зөрчил. Хүүхдийг аливаа эрсдэл, хүчирхийллийн аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлж хамгааллахын тулд Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, үйл жиллагаандаа гарч болоххүүхэд хамгааллын зөрчлийн бүхий л эрсдэлийг хүүхэдтэй шууд болон шууд бус харьцдаг байгууллага бүрийн оролцоотойгоор бууруулан ажиллана.

ГУРАВ: ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү бодлого нь байгууллагын үндсэн болон гэрээт бүх ажилтан албан хаагчид, сайн дурын ажилтан, дадлагын оюутан болон бүхий л иргэнд хамаарна.

ДӨРӨВ: НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Хүүхэд: 18 нас хүртэлх хүн бүрийг хүүхэд гэнэ.

Хүүхэд хамгаалал: Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, мөлжлөг гарахаас урьдчилан сэргийлэх, хариу үйлдэл үзүүлэхэд чиглэсэн санаачилга, үйл ажиллагаа юм.

Хүүхдэдээлтэйбайгууллага: Бие махбод, бэлгийн, сэтгэл санааны, сэтгэл зүйн хохирол, үл хайхрах байдлаас хүүхдийг хамгаалах үйл ажиллагааг байгууллагын бүх түвшинд нэвтрүүлсэн, дадал болгосон, дотоод журамдаа тусгасан, байгууллагын соёлд нэвт шингээсэн байгууллага

Хүүхэд хамгааллын бодлого: Хүүхдэд учрах эрсдэл, хор нөлөөнөөс сэргийлж, хамгаалахын тулд байгууллага бүр анхаарал тавьж байгааг нотолсон баримт бичиг. Түүнд хүүхэд бүрт аюулгүй, эерэг орчин бүрдүүлэхийн тулд байгууллага, ажилтнууд, сайн дурын идэвхтнүүд болон бусад холбогдох хүмүүс юуг анхаарах ёстойг тусгасан байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл: Дараах хэлбэрээр хүүхдийн бие махбод, сэтгэл санааны халдашгүй дархан байдлыг алдагдуулах үйлдэл

- Бие мах бодын хүчирхийлэл
- Бэлгийн хүчирхийлэл
- Сэтгэл санааны хүчирхийлэл

- Үл хайхрах

Бие махбодийн хүчирхийлэл: Зодох, цохих, өшиглөх, хазах, түлэх, сэгсрэх чимхэх гэх мэт ямар нэгэн байдлаар хүүхдийн бие махбодод байнга халдах, бие мах бодын гэмтэл учруулах үйлдэл

Бэлгийн хүчирхийлэл: Хүүхдийг бэлгийн таашаал авахдаа ашиглах, эдийн засгийн ашиг олохоор биеийг нь үнэлүүлэх үйлдэл

Сэтгэл санааны хүчирхийлэл: Байнга голох, доромжлох, нэр төрийг нь гутаах, хүний эрхийг нь үгүйсгэх гэх мэтээр өөртөө итгэх итгэл, нийгмийн чадамжаа хүүхэд аажмаар гээхэд хүргэж байгаа бусдын сөрөг зан үйл

Үл хайхрах: Хүүхдэд анхаарал тавихыг шууд, санаатайгаар орхигдуулж, тэдний наад захын хэрэгцээг хангах явцдаа алдаа гаргах үйлдэл

Хүүхдийг садар самуунд ашиглах: Бэлгийн амьдралыг ил тод харуулан дүрслэн бичсэн бичлэг, видео бичлэг, зураг бүтээхдээ хүүхдийг оролцуулах үйлдэл

Мөлжлөг: Хүүхдийн эмзэг байдлыг ашиглан тэднийг хүнд хөдөлмөр эрхлүүлэх, наймаалах, садар самуун болон бусад эрсдэлт үйл ажиллагаанд уруу татан ашиг хонжоо олох үйлдэл

Үе тэнгийнхний хүчирхийлэл: Нэг хүүхэд нөгөө хүүхэддээ бие махбодын эсвэл сэтгэл санааны дарамт үзүүлдэх үйлдэл. Мөн бэлгийн хүчирхийлэл энд орно. Энэ нь айлган сүрдүүлэх, зодох, байнга дооглох, тохуурхах, гадуурхах, бүлэглэн гадуурхах, нэр хоч өгөх зэрэг төрөл бүрийн хэлбэрээр илэрч болно. Цахим харилцаагаар дарамтлах, сүрдүүлэх, тохуурхах, нэр төрийг гутаан доромжлох үзэгдэл энэ нэр томъёонд хамаарна.

Хүүхэдтэй зүй бус харьцах явдал: Хүүхдийг асран хамгаалах үүрэг хүлээсэн эцэг эх асран хамгаалагч, хүмүүжүүлэгчийн зүгээс хүүхдэд сэтгэл санааны дарамт, бие махбодийн болон бэлгийн дарамт, хүчирхийлэл үзүүлэх, улмаар хүүхдийг мөлжих байдлаар хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, аюулгүй байдалд хор хөнөөл, аюул занал учруулсан буюу учруулах эрсдэлтэй бүхий л үйлдэл

ТАВ: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Хүүхэдтэй ажилладаг байгууллага нь хүүхэд хамгааллын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрсдэл бууруулах, мэдээлэл хүлээн авах, хариу хариу үйлдэл үзүүлэх арга хэмжээ авна.

5.1 ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- Удирдах албан тушаалтан, ажилтан орсон Хүүхэд хамгааллын нэгж байгуулна. Нэгж нь Байгууллагын хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөж, зохион байгуулна.
- Бодлогыг нийт ажилтан, бусад хүмүүст харагдахуйц газар байнга байрлуулна.

5.2 УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

Сургалт сурталчилгаа, мэргэжлийн туслалцаа

- Ажилтнуудад хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, эерэг хүмүүжлийн арга, холбогдох хууль эрхийн актуудын талаар мэдээлэл өгч, сургалт явуулна.
- Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхэд хамгааллын бусад асуудлууд, хор нөлөөний талаар ажилтнуудад сургалт явуулж, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамт хүүхдийн байгууллага дотор байж үл болох талаар нээлттэй ярилцаж, аливаа зөрчлийг нуун дарагдуулдаггүй соёлыг төлөвшүүлнэ.
- Ажилтнуудыг ажил мэргэжлийн онцлогт шаардлагатай мэдээлэл, мэргэжлийн удирдлагаар хангана. [Тухайлбал, халамж, асрамжийн байгууллага, дотуур байр ажиллуулдаг байгууллага нь ажилтнуудын хүмүүжил, зан үйлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чадварыг сайжруулах сургалтыг тогтмол явуулж тэдэнд мэргэжлийн туслалцаа үзүүлж байна.]
- [Боловсролын салбар эерэг хүмүүжлийн аргыг сургалтын ажилд хэрхэн хэрэглэх тухай сургалтанд бүх багш нарыг хамруулна. Багш бэлтгэх бүх сургалтын хөтөлбөрт энэ сэдвийг оруулна. Эрүүл мэндийн байгууллага хүүхдийн эсрэг хүчирхийллийн шинж тэмдгийг таньж мэдэх талаар гарын авлага боловсруулж ажилтнуудад сургалт тогтмол явуулна.]

Ажилтан шалгаруулах

- Хүүхдэд хор хохирол учруулж болзошгүй хүнийг ажилд орохоос урьдчилан сэргийлэхийн тулд хүүхэдтэй зүй бусаар харьцаж байсан эсэх, хүүхэдтэй харьцах чадварыг ажилтан шалгаруулах үзүүлэлтэд оруулна.
- Ажлын орон тоог зарлахдаа “Бид Хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлдэг байгууллага. Бид хүүхдийн эсрэг хүчирхийллийг тэвчихгүй” гэж тусгана.
- Ажилд орохыг хүсэгч нь өргөдөлдөө “Байгууллагын хүүхэд хамгааллын бодлогыг хүлээн зөвшөөрнө” гэсэн мэдэгдэл хийнэ.
- Ажилд орохыг хүсэгчийг 2-оос дээш жилийн хугацаанд таних 2 хүнээс зан байдлын тодорхойлолт гаргуулна. Тэр нь гэр бүлийн гишүүн байж болохгүй. Тодорхойлолтыг гаргуулахдаа “Хавсралт 1”-д өгсөн загварыг ашиглаж болно.
- Ажилд шинээр орох гэж буй хүний тухай цагдаагийн газраас “Хүүхдэдтэй зүй бус харьцаж байсан эсэх талаар” тодорхойлолт авна.

Хүүхэд хамгааллын Ёс зүйн дүрэм

- Нийт ажилтнууд болон шинээр ажилд орж байгаа хүмүүс Хүүхэд хамгааллын Ёс зүйн дүрэмтэй танилцан гарын үсэг зурна (Загвар Хавсралт 2-д).

- Хүүхэд хамгааллын Ёс зүйн дүрмийг зөрчсөн ажилтанд зөвлөх, зааж сургах, сахилгын арга хэмжээ авах, үүрэгт ажлаас нь өөрчлөх, түтгэлзүүлэх, чөлөөлөх эсвэл хуулийн хүрээнд шийдвэрлүүлэхээр ажлын гэрээнд тусгана.

5.3. ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ

- Хүүхдэд хор хөнөөл учруулж болзошгүй эрсдэл байгууллагын үйл ажиллагаанд оршиж байгаа эсэхэд судалгаа хийж, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.
- Байгууллага онцлогтоо тохируулан хүүхдийн хувийн нууцыг хадгалах, хүндэтгэх журам батлан хэрэгжүүлнэ. (Загвар Хавсралт 3-д).
- [Халамж, асрамжийн төв, хүүхэдтэй шууд тулж ажилладаг, эсхүл хүүхдийн тухай мэдээллийг хэрэглэдэг, хадгалдаг бүх байгууллага хүүхдийн мэдээллийн сан, файлыг хадгалах, ашиглах талаар журам гаргаж хэрэгжүүлнэ.]
- Хүүхэдтэй шууд тулж ажилладаг боловсрол, халамж асрамжийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага, хүүхдийн зуслан, 18 хүртэлх насны хүүхэд амьдардаг дотуур байр ажиллуулдаг бүх шатны сүргүүлиуд эрсдэлийг бууруулахын тулд дараахь нэмэлт арга хэмжээг авна.

✓ Хүүхэд байгаа орчны аюулгүй байдал

- Хүүхдийн амьдардаг, амардаг, сурдаг орчинд гадна болон дотоод орчны зүгээс учирч болзошгүй хүчирхийлэл, дарамтаас сэргийлэх бүхий л арга хэмжээг авна. Хүүхдийг халамжийн төв, дотуур байр, зусланд байрлуулахдаа нас, хүйс, хөгжлийн бэрхшээл болон хүүхдийг эмзэг байдалд оруулж болзошгүй бусад эрсдэлийг бий болгож болзошгүй хүчин зүйлүүдийг харгалзан үзэж аюулгүй орчинг бүрдүүлнэ.
- Хүүхдийг харгалзан хамгаалалгүйгээр орхихгүй байх арга хэмжээг авна.

✓ Хүүхдийн оролцоо

- Хүүхдүүдэд Хүүхэд хамгааллын бодлогыг тэдэнд ойлгомжтой хэлбэрээр танилцуулж, санал бодлыг бодлогод тусгана.
- Хүүхдэд зориулсан Хүүхэд хамгааллын бодлогын хувилбарыг тэдэнд ойлгомжтой хэлбэрээр боловсруулна.
- Өөрийгөө хамгаалах болон бусад хүүхдийн эрхийг хүндэтгэх талаар хүүхдүүдэд мэдээлэл өгч, сургалт сурталчилгаа явуулна.
- Хүүхдүүдтэй зөвлөлдөн тэдэнд зориулсан зөрчил, эрсдэлийг аюулгүйгээр мэдээллэх арга механизмыг тодорхойлно. **Хүүхэд мэдээллэх үүрэг хүлээхгүй**, харин тэднийг мэдээллэхийг дэмжинэ.
- Байгууллагын дотоод мэдээллийн механизмыг ашиглах нь зарим тохиолдолд хүүхдэд эрсдэл авчирдаг тул байгууллагаас гаднах хүүхэд хамгааллын үйлчилгээнд мэдээллэхийг дэмжиж, холбогдох хаягийг өгнө.
- Мэдээлэл өгсөн хүүхдийн аюулгүй байдлыг хангана.

✓ **Эцэг эхийн оролцоо**

- Эцэг эхчүүдэд Хүүхэд хамгааллын бодлогын тухай мэдээллийг өгнө.
- Хүүхдэд, ялангуяа бага насны хүүхдэд учирсан хамгааллын зөрчлийг хэрхэн таних, мэдээллэхталаар эцэг эхэд зөвлөгөө өгнө.

✓ **Үе тэнгийнхний хүчирхийлэл, дарамт**

- Хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгч нь зөвхөн насанд хүрэгч байдаггүй, хүүхэд бас байж болдгийг сайн ойлгож хүүхэд хүүхэд ээ хүчирхийлэх, дарамтлах үзэгдлийг арилгахын тулд хүүхдийн бүх төлөөллийг оролцуулан эрсдэлийг тооцож, бууруулах бүхий л арга хэмжээг авна. Үүнд амьдрах ур чадварын сургалт явуулах, хүүхдийн зан үйлийн зөрчлийг шийдвэрлэх журмыг хүүхдүүдтэй хамтран боловсруулах зэрэг үйл ажиллагаа орно.
- Хүүхэд хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд хариу авах үйлдлийг хүүхдийг оролцуулан боловсруулна.

5.4. ЗӨРЧЛИЙН ТАЛААРХИ МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ

- Ажилтан болон бусад хүн бүр хүүхдийн эсрэг аливаа хүчирхийлэл, мөлжлөгийн талаар байгууллагын даргад болон хүүхэд хамгааллын нэгжийн ажилтанд шууд мэдээллэх үүрэгтэй.
- Байгууллага хүүхэд хамгааллын зөрчлийг мэдээллэх, мэдээлэл хүлээн авах, хариу үйлдэл үзүүлэх механизмыг боловсруулан батална (Загвар Хавсралт 4). Мэдээллийн эх үүсвэр, төрөл нь:
 - Байгууллагын ажилтан болон бусад хүмүүс Хүүхэд хамгааллын Ёс зүйн дүрмийг зөрчсөн болон зөрчсөн байж болзошгүй үйлдэл, зан үйлийн талаар;
 - Байгууллага дээр болон байгууллагаас явуулж буй үйл ажиллагааны үеэр хүүхэд хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үлхайд харах байдалд өртсөн буюу өртсөн байж болзошгүй сэжгийн талаар;
 - Орон нутаг, тодорхой газар хүүхдийн аюулгүй байдал алдагдсан, хүүхэд хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн болон өртсөн байж болзошгүй талаар;
- Мэдээллийг амаар, эсвэл Хавсралт 5-д заасан загвар мэдээллэх хуудсыг бөглөж өгч болно. Хүүхдийн эрх ашгийн төлөө нууцаар мэдээлэл өгч болно.
- Мэдээллэгчийн аюулгүй байдлыг эрхэмлэнэ. Мэдээллэгчид өс хонзон санах, аюулгүй байдалд нөлөөлөх аливаа үйлдэл, хандлагыг хүлээн зөвшөөрөхгүй.
- Тодорхой шалтгааны улмаас ажилтнууд мэдээллийг байгууллагын хүүхэд хамгааллын нэгжид өгөхөөс гадна орон нутгийн хүүхэд хамгааллын болон хууль цагдаагийн байгууллагад өгч болно.

5.5. ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ

Хүүхэд хамгааллын зөрчил нь хэзээ ч хүлээн зөвшөөршгүй зүйл гэж үзэж, ийм зөрчлийн талаар ирсэн мэдээлэлд хариуцлагатай хандана.

- Байгууллага нь хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар гомдол мэдээллийн мөрөөр ажиллахдаа хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хамгааллахад бүхий л хүчин чармайлтаа гарган ажиллана.
- Хариу үйлдэл үзүүлэхдээ уг үйл ажиллагааны улмаас хүүхдийг дахин хохирогч болгохгүй байхад онцгой анхаарал хандуулан ажиллана.
- Нарийн төвөгтэй асуудалд нухацтай хандаж бүх талд шударга хандана.
- Бүх мэдээллийн нууцыг чанд сахиж, асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэнэ.
- Мэдээллийг хүлээн авсан хүүхэд хамгааллын нэгж байгууллагын удирдлагатай зөвлөж тухайн нөхцөлд тохируулан дараагийн алхмыг хэрэгжүүлнэ.
 - Хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул заналхийлсэн учрахуйц нөхцөл байдал үүссэн нь тохиолдолд бол хүүхдийг аюулаас зайлуулахыг арга хэмжээг нэн тэргүүн авна.
 - Нэмэлт мэдээлэл цуглуулна.
 - Хэрэв тухайн асуудал нь гэмт хэргийн шинжтэй бол:
 - ✓ Хууль цагдаагийн байгууллагад яаралтай мэдэгдэж, хэргийг шилжүүлнэ. Гэмт хэрэг мөн эсэхийг зөвхөн хууль цагдаагийн байгууллага тогтооно. Мөн тухайн орон нутгийн эрх мэдэл бүхий хүүхэд хамгааллын байгууллагад давхар мэдэгдэнэ.
 - ✓ Гэмт хэргийн шинжтэй хэргийн хохирогч хүүхдийн нөхөн сэргээх, хохирлыг бууруулах асуудлаар орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллага кейсийн ажилтан томилон тухайн байгууллага, шаардлагатай бол бусад мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.
 - ✓ Хууль цагдаагийн байгууллага болон орон нутгийн эрх мэдэл бүхий хүүхэд хамгааллын байгууллага хэргийн явцын болон эцсийн үр дүнгийн талаар тайлан мэдээллийг тухайн хэрэг шилжүүлсэн байгууллагад бичгээр хүргүүлнэ.
 - Хэрэв тухайн асуудал нь гэмт хэргийн шинжгүй бол:
 - ✓ Буруутай этгээдийн асуудлыг дотооддоо шийдвэрлэнэ.
 - ✓ Хохирогч хүүхдэд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх талаар мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх боломжгүй байгууллага орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллага болон мэргэжлийн байгууллагад холбон зуучилна.

6. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Ёс зүйн дүрмийн гол зорилго нь хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалахад оршино. Дараахь жагсаалтад зөвхөн зарим жишээг дурдсан болно. Гол зарчим нь байгууллагынаж илтнэ зүгээс хүүхэд хамгааллын эрсдэл, зохисгүй занавир гаргахгүй байхад оршино.

Эрсдлийг үнэлэн	
Үргэлж анхаарах	✓ Хүүхэд, том хүн хоёрын эрх мэдлийн зөрөөг ойлгож хүүхдэд дээрэнгүй хандахгүй байх; ✓ Харилцааны зөв үлгэр дууриалал үзүүлэх; ✓ Хүүхдийг хүмүүжүүлэхдээ бие махбодийн шийтгэл хэрэглэхгүй байх, эерэг хүмүүжлийн аргыг ашиглах; ✓ Хүүхдийн хувийн нууцлалд хүндэтгэлтэй хандах; ✓ Хүүхдийг ашигласан садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг бусад зүйлсийг хэрэглэх нь хүүхдийг садар самуунд ашиглахыг дэмжиж байгаагийн илрэл болохыг ойлгож, ийм зүйлсээс татгалзах; ✓ Хүүхдийн өөрөө хийж чадах зүйлийг өмнөөс нь хийхгүй байх; ✓ Хүүхэд хамгааллын зөрчлийг гэтэвчихгүй байх, мэдээллэх, асуудлыг нуундарагдуулдаггүй, нээлттэй ярилцдаг соёлыг түгээх; ✓ Ажлаат өлөвлөх, гүйцэтгэхдээ хүүхдийн амь нас, эрүүл мэндэд хохирол үзүүлж болзошгүй аливаа эрсдэлийг тооцож, сэргийлэх; ✓ Хүүхдийн дунд гарч болзошгүй үе тэнгийнхний хүчирхийллийн талаар сонор сэрэмжтэй байх; ✓ Хүүхэд хүн дамлан худалдах наймааны золиос болох зэрэг хүүхдэд хоручруулах үйл ажиллагаанаас сэргийлэх.
Хориглох	☒ Хүүхдийг цохих, зодох, тусгаарлан хорих зэргээр бие махбодын хүчирхийлэлд оруулах; ☒ Хүүхдийг гутаах, ичээх, доромжлох, дорд үзэх, сэтгэл санааны дарамтанд оруулах, нэр хоч өгөх; ☒ Хүүхэдтэй бэлгийн харилцаанд орох, уруу татах, биеийг үнэлүүлэх; ☒ Хүүхдийг бэлгийн харьцаа хандлагаар өдсөн тоглоом тоглох, шалиг үг яриа ярих зэргээр биеэ завчявах, бусдад тийм боломж олгох; ☒ Хууль бус эсвэл хүүхдэд аюултай үйлдэл гарсан тохиолдолд түүнийг тоохгүй орхих; ☒ Хүүхдийн дэргэд хараал, бүдүүлэг үг хэрэглэх; ☒ Хүүхдийг ямар нэг байдлаар нь ялгаварлан харьцах.

7. АЖИЛТНУУДЫГ ЭЦЭГ ЭХИЙН ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

- Эцэг эх болон хүүхэд асран хамгаалагч ажилтнуудад эцэг эхийн үүргээ биелүүлэх, хүүхэдтэйгээ цаг өнгөрөөх, хүүхдэдээ халамж анхаарал тавих боломжийг олгох талааранхаарчажиллана.

Хавсралт 1

Хүүхэд хамгааллын Ёс зүйн дүрмийг хүлээн зөвшөөрөх тухай байгууллагын

.....ажилтан

Батламж

20.. оны .. сарын өдөр

Дугаар:

_____ургийн овгийн _____ний /ны/ _____, миний бие нь энэхүү байгууллагын Хүүхэд хамгааллын бодлогод дурдсан ёс зүйн дүрмийг уншиж ойлголоо. Би энд дурдсан зарчмуудыг хүлээн зөвшөөрч энэ байгууллагад ажиллаж байх хугацаандаа хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэхийн чухлыг ямагт санаж явах болно. [Хүүхэд хамгааллын Ёс зүйн дүрмийг хавсаргана.]

(Овог нэр)

(Албан тушаал)

(Гарын үсэг)

(Огноо)

Хавсралт 2

ЗАН БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ ГАРГУУЛАХ ХҮМҮҮСИЙН ХАЯГ БОЛОН ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОЖ БАЙСАН ЭСЭХЭЭ ШАЛГУУЛАХ ТУХАЙ

Зан байдлын тодорхойлолт гаргах хүмүүс

Таны зан байдлын талаар тодорхойлолт өгөх боломжтой таныг 2 жилээс дээш хугацаагаар таних 2 хүний нэр, холбоо барих хаягийг бичнэ үү! (Гэр бүлийн гишүүдийг оруулахгүйгээр)

Тодорхойлогч 1:

Нэр:	
Гэрийн хаяг:	
Утас, э:шуудан:	

Тодорхойлогч 2:

Нэр:	
Гэрийн хаяг:	
Утас, э:шуудан	

Гэмт хэргийн улмаас шийтгүүлж байсан эсэх

Та өмнө нь ял шийтгэл эдэлж байсан уу? Тийм ____ Үгүй ____
Хэрвээ тийм бол, ял шийтгэлийн талаар бичнэ үү? Энэхүү мэдээллийн нууцыг сахих бөгөөд Хүүхэд хамгааллын хувьд ямар нэгэн эрсдэл байна уу гэдэгт байгууллагын захирал үнэлгээ хийхэд л ашиглах юм.

--

Хавсралт 3

АЖИЛ ХЭРГИЙН ЗОРИЛГООР ХҮҮХДИЙН ЗУРГИЙГ АВАХ, ХҮҮХДИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЛИЙГ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛД АШИГЛАХ ЖУРАМ

- Хүүхэд хувийн амьдрал, нууцлалаа хамгаалуулах эрхтэй. Мөн хүүхдийн эмзэг байдал, хүчирхийллийн хохирогч болсон эсвэл эцэг эхийн халамж анхаарлын гадна байдаг зэрэг байдал нь түүнийг дахин хохирогч болгох эрсдэлтэй байдаг тул хүүхдийг хэвлэл мэдээлэлд ашиглахдаа болгоомжтой хандана.
- Хүүхдийн зургийг авах, дүрс бичлэг хийхийн өмнө хүүхэд, хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчаас зөвшөөрөл авна. Мөн зургийг хаана, хэрхэн ашиглахыг тайлбарлана.
- Хүүхдийг зургийг болон хүүхдийн тухай мэдээллийг хэвлэл мэдээлэлд ашиглахдаа хүүхэд бүрийн нэр төрийг дээдэлнэ.
- Хүүхдийн зураг, дүрс бичлэг, DVD нь хүүхдийг хүндэтгэсэн байдалтай байгаа эсэхийг хянана. Хүүхэд тохиромжтой хувцасласан байхад анхаарна.
- Тухайн зураг нь тухайн сэдэв, үйл явдлын үнэн зөв төлөөлөл болж байгааг хянана.
- Хүүхдийн гудамжинд эсвэл асрамж халамжийн төвд амьдардаг эсвэл эрх нь зөрчигдсөн зэрэг эмзэг, эрсдэлтэй байдлын талаар мэдээлэл хийхдээ хүүхдийг танигдуулахгүй байдлаар зургийг авч, мэдээллийг өгнө.
- компани, хувь хүмүүс хүүхдэд тусламж өгөх зэрэг үйл ажиллагаа нь сайшаалтай боловч тэдний энэ үйл ажиллагааг хэвлэл мэдээллээр сурталчлах явцад хүүхдийн нэр хүнд, хувийн амьдралд халдсан зөрчил гарч болзошгүй тул үүнээс сэргийлж, хүүхдийг танигдахгүйгээр зургийг авч, мэдээллийг өгнө.
- Зураг, файл нь хүүхдийн нууцыг хөндсөн эсэхийг сайтар хянан, хувийн нууцыг хамгаалан, үйл ажиллагаандаа зохих хэлбэрээ ашиглах зөвшөөрөл хүснэ.

Хавсралт 4

ДАГАЛДАН АЯЛАГЧ НАСАНД ХҮРЭГЧИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХ ЖУРАМ

Дагалдан аялагч гэдэг нь : Хүүхдийг албан ёсны үйл ажиллагаанд эцэг эхээс нь зохих зөвшөөрөл авсан хариуцаж авч яваа итгэмжлэгдсэн хүн байна.

Дагалдан аялагч нь Аймгийн Хүүхэд хамгаалах бодлоготой танилцаж, насанд хүрэгчийн хариуцлагыг аялалын турш мөрдөж ажиллана.

а/ Аялалын хугацаанд хүүхдэд дэмжлэг туслалцаа үзүүлэх, үүнд хүүхдийг нисэх буудал хүртэл авч явах, гаалийн шалгалтаар ороход болон нисэх онгоц, машинд суухад нь туслах зэрэг болон тээвэрлэж авч явахад аюулгүй байдлыг бүрэн хангана.

б/ Бүхий л хугацааны турш хүүхдийн ойр орчимд байж түүний байгаа газрын талаар мэдэж байх, насанд хүрэгчийн хэн хэн нь холбоо барих утастай байх.

в/ Хүүхдийн бие махбодийн болон сэтгэл зүйн хэрэгцээ шаардлагыг мэдэрч, түүний хэрэгцээ шаардлагыг зохистойгоор хангахад туслалцаа үзүүлэх

г/ Хүүхэд бусадтай /ялангуяа бусад хүүхдүүдтэй/ орчуулагчаар дамжуулан харилцах чадвартай байх явдлыг хангах

д/ Хүүхдийн амарч алжаалаа тайлах, ажил, арга хэмжээ болон ярилцлагад оролцох боломжийг хангах

е/ Аймгийн хүүхэд хамгаалах бодлогын хүрээнд салбарын холбогдох хүмүүс /арга хэмжээ зохион байгуулагчдад өөрийн асран хамгаалж яваа хүүхдэд тохиолдож болох хүндрэлтэй нөхцөл байдлуудын талаар мэдээлэх, урьдчилан сэргийлэх

ё/ Хүүхдэд шаардлагатай болж болох аливаа бусад бие махбодийн болон сэтгэл зүйн хэрэгцээ шаардлагыг хангах. Үүнд: Дагалдан аялагч насанд хүрэгч нь бүхий л хугацааны турш хүүхдэд шаардлагатай эмнэлгийн болон бусад яаралтай тусламжийн талаар мэдээлэлтэй байх, эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай болох тохиолдолд өөрсдийнх нь өмнөөс үйл ажиллагааг зохицуулахыг зөвшөөрч эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс гаргасан бичгэн зөвшөөрлийг цаг ямагт биедээ авч явах зэрэг багтана.

ж/ Хүүхэд өвдсөн, гэнэтийн болзошгүй зүйлээс урьдчилан сэргийлэх зорилгоор дагалдан аялагч насанд хүрэгч нь хүүхэдтэй ганцаар цаг хугацааг өнгөрүүлэх тохиолдолд дээд шатны удирдах ажилтанд 24 цагийн дотор мэдэгдэх ёстой.

з/ Онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд дагалдан аялагч насанд хүрэгч нь 25-аас дээш насны байна.

и/ Шаардлагатай бичиг баримтыг бүрэн гүйцэд биедээ авч явах

ХОРИГЛОХ ЗҮЙЛС:

- Хүүхдэд ялгаварлан гадуурхах байдлаар хандах, зарим нэг хүүхдийг онцгойлон хайрлаж халамжлах
- Хамт аялан явж буй хүүхдээ дагалдан аялагч насанд хүрэгчийн өрөөнд бүтэн шөнийг өнгөрүүлэхэд хүргэх
- Хүүхдүүдэд согтууруулах ундаа, тамхи, хориотой эм тан санал болгох, доромжлолын хэлбэртэй зан байдалтай эвлэрэх, хүчирхийллийн аливаа хэлбэрийг үйлдэхгүй байх, илэрсэн тохиолдолд мэдээллэх арга хэмжээ авах
- Хүүхдийн фото зураг болон түүх, намтарыг хэвлэхдээ тэдний нэр төрийг хүндэтгэх, эмзэг байдлынх нь тухай онцлон дурдахыг хориглоно.

[Хавсралт 5](#)**Хүүхэд хамгааллын зөрчлийн талаар мэдээлэх хуудас**

Хэрвээ хүүхдэд ямар нэгэн аюул учирсан талаар мэдэж байгаа бол та доорхи хүснэгтийг бөглөнө үү?

1. Таны мэдээлэл

Нэр: _____

Хаана ямар ажил эрхэлдэг: _____

Тухайн хүүхэдтэй ямар холбоотой вэ: _____

Холбоо барих хаяг, утас: _____

2. Хүүхдийн мэдээлэл

Хүүхдийн нэр: _____

Хүүхдийн хүйс, нас _____

Хүүхдийн гэрийн хаяг: _____

Хүүхдийн асран хамгаалагчийн нэр: _____

1. **Хэргийн сэжгийн тухай, аль болох тодорхой** бэлгийн бие махбодийн, сэтгэл санааны, хүчирхийлэл, шийтгэл, мөлжлөг, үл хайхрах байдал

2. Сэжиглэгдэж буй үйлдлийн болсон он сар өдөр цаг _____

Сэжиглэгдэж буй үйлдэл хаана болсон бэ? _____

Тус үйлдлийг үйлдсэн сэжигтний нэр _____

Нэмэлт мэдээлэл _____

Хаа нэгтээ хүүхэд дарамт, хүчирхийлэл, үл хайхрах байдал, мөлжлөгт өртөж болзошгүй, эсвэл өртөж байгааг мэдсэн хүн бүр байгууллагадаа болон зохих газарт хандан мэдээлнэ:

- Хүүхдийн нөхцөл байдал хүнд бол ?
- Яаралтай туслах

→ **Тийм** →

- түргэн тусламж -(103)
- Цагдаа - (102), (105) дуудан

үгүй

- Байгууллагын захиргаа, хүний нөөцөд давхар мэдэгдэх -

- хүүхдийн тусламжийн утсаар ("108") хандах
- сум, дүүрэг, хороонд Засаг дарга, Тамгын газар, нийгмийн ажилтан, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төвд
- Аймаг, нийслэлд: Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, газарт
- Хүний эрх, хүүхдийн эрхийг хамгаалах иргэний болон олон улсын байгууллага, салбарт сонгон хандах.

Хүүхдийн эрхийн зөрчлийн мэдээлэх хуудсыг бөглөх ба 24 цагийн дотор байгууллагын захиралд албан ёсоор мэдэгдэнэ

Байгууллагын удирдлага хүүхдийн хамгааллын бодлого, ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн мэдээллийн мөрөөр арга хэмжээ авч шийдвэрлэнэ.

хүүхэд залуучуудын хөгжлийн газар

